

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛСАН “МЭДЭЭЛЛИЙН ЦАГ” АРГА ХЭМЖЭЭ

Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын "Баганат танхим"-д байрлах Иргэний танхимд 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газраас “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим системийн сургалт” системийн талаарх сургалтыг зохион байгууллаа.

Уг сургалтаар системийн танилцуулга, хэрхэн төлөвлөгөөг системд оруулах, зайлшгүй анхаарах асуудлын талаар танилцуулж, сургалтын үр дүнд ЗГХЭГ-ын төрийн жинхэнэ албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим системд оруулсан болно. Сургалтад 91 хувийн ирцтэйгээр албан хаагчид оролцлоо.

